



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 4/09

Модот

**Хөдөлмөрийн дотоод журам
шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.6, 43.1.7, 122 дугаар зүйлийн 122.1, 122.2, 122.3 дах заалт, хамт олны саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн хавсралтаар баталж, 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.
2. Хөдөлмөрийн дотоод журмыг нийт багш, ажилтанд танилцуулж, мэдээллийн самбарт байршуулахыг сургалтын менежер (Д.Ариунаа)-д даалгасугай.
3. Хөдөлмөрийн дотоод журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах, хэрэгжүүлэхийг нийт багш, ажилтанд үүрэг болгосугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэж баталсан Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн Хөдөлмөрийн дотоод журмыг хүчингүй болсонд тооцсугай.
5. Хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт шалгалтын багийн ахлагч (Б.Гэрэлмаа)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Д.ОТГОНДУЛАМ